

## **“БОГДБАНК” ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү ногдол ашгийн журам (цаашид “Журам”гэх) нь ”Богдбанк” ХХК- ийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг бөгөөд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, хуваарилах ногдол ашгийн хэмжээ, хуваарилах нөхцөл журмыг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, СЗХ-оос гаргасан Компанийн засаглалын кодекс, “Богдбанк” ХХК-ийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөөлөн удирдах зөвлөлөөс энэхүү журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

1.3. Компанийн хувьцаа эзэмшигч болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад энэхүү журам нь компанийн ногдол ашиг хуваарилалтын бодлого, хэмжээ, хуваарилах арга хэлбэрийн талаар тодорхой нэгдсэн ойлголтыг өгөх болно.

### **ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО**

2.1. Энэхүү ногдол ашгийн бодлого нь Монголбанкнаас тавьсан шаардлага, компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.

2.2. Компанийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.

2.3. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 35-р зүйлийн 35.3 дах заалт, энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд тухайн тайлангийн хугацаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг татвар төлсний дараах цэвэр ашгаас , компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын болон өөрийн хөрөнгийн хэрэгцээ зэрэгтэй уялдуулан компанийн гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

2.4. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд энэхүү мөнгөн дүнд нийцүүлэн эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

### **ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ**

3.1. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

3.2. Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

3.2.1 Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

3.2.2 ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, Банкны дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэргийн нийлбэрээс их байх;

3.2.3 Компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;

3.2.4 Ногдол ашиг хуваарилсны дараа Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангагдаж байхаар бол.

3.3. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25 хувиас дээш хувиар багассан тохиолдолд Банк нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зээлдүүлэгчид болон Монголбанкинд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

### **ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ШИЙДВЭР**

4.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь жилийн санхүүгийн тайлангийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ. Улирлын санхүүгийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилах эсэхийг энэхүү бодлогын 2,3-т заасны нөхцөл бүрдсэн эсэх талаарх Гүйцэтгэх Захирлаас ирүүлсэн саналыг үндэслэн ТУЗ-өөс шийдвэрлэнэ.

4.2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна:

4.2.1. хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;

4.2.2. ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

4.2.3. ногдол ашиг төлөх өдөр буюу олгож эхлэх, дуусах хугацаа;

4.2.4. ногдол ашгийг олгох арга зам, хэлбэр;

4.3. Компани нь тухайн жилийн санхүүгийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа үндэслэл шалтгаан, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

4.4. Хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол хуучин хувьцаа эзэмшигчид үлдэнэ.

#### **ТАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ**

5.1. Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль хялбар бөгөөд нэмэгдэл зардал гаргахгүйгээр авах бололцоог хангасан байна.

5.2. Ногдол ашгийг төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлнө.

5.3. Тогтоосон хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухай хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

5.4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигч бүрийн нэр дээр төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгана.

5.5. Ногдол ашгийг [хувьцаа эзэмшигчийн тодорхойлсон дансанд шилжүүлэх бодлого баримтална. Хэрэв үнэт цаасны компаниар дамжуулан өгөх тохиолдолд ногдол ашгийн мөнгийг ногдол ашиг авах ХЭ бүрийн нэр, регистерын дугаар, авах ногдол ашгийн хэмжээ зэргийг үзүүлсэн жагсаалтын хамт хүргүүлж энэ тухайгаа ХЭ нарт мэдээллийн хэрэгслээр болон тэдгээрийн цахим хуудсаар мэдээлнэ.

5.6. Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.

5.7. Ногдол ашиг хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гарган Монголбанкинд хүргүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг заавал тайлагнана.

ооОоо